

Ard Даатгал
ХК

2025 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

01

МЭНДЧИЛГЭЭ

ТУЗ-ийн даргын илгээлт	03
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	04

02

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн танилцуулга	05
Тоон үзүүлэлт	05
Даатгалын үйл ажиллагаа	07
Онцлох үйл явдлууд	09

03

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Ердийн даатгалын салбарын өнөөгийн байдал	10
---	----

04

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа	11
Хувьцаа эзэмшигчдийн хурал	12
Хувьцааны арилжааны мэдээ	12
Хувьцаа эзэмшигчийн бүтэц	12
Төлөөлөн удирдах зөвлөл	13
Гүйцэтгэх удирдлагын баг	14
Хүний нөөц	15

05

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлага	19
Давхар даатгалын үйл ажиллагаа	20
Нөхөн төлбөрийн үйл ажиллагаа	21
Комплайнсын хөтөлбөр	21

06

2025 ОНЫ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	24
Санхүүгийн байдлын тайлан	25
Өмчийн өөрчлөлтийн тайлан	26



Нийт хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, даатгуулагч, харилцагч, хамтран ажиллагч түншүүд ээ,

2025 онд Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт өмнөх оноос өсөж 6.8 хувь буюу 89.9 их наяд төгрөгт хүрчээ. Эдийн засгийн өсөлтөд бүхий л салбарууд нөлөөлсөн бөгөөд хөдөө аж ахуй, үйлдвэр, үйлчилгээ, уул уурхайн салбар голлох нөлөө үзүүлсэн байна. Монгол улсын санхүүгийн секторын нэг даатгалын салбарын голлох үзүүлэлтүүд 2025 онд мөн өссөн үзүүлэлттэй байсныг Санхүүгийн Зохицуулах хорооноос эрхлэн гаргадаг даатгалын салбарын 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны нэгдсэн тайланд дурдсанаар даатгалын гүнзгийрэл 0.64 хувиас 0.66 хувьд хүрч 2 пунктээр өссөн, даатгалын нягтрал 164.9 мянган төгрөг хүрч өмнөх оноос 15%-аар өссөн үзүүлэлттэй байна.



Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 2024 оноос 15.8 хувиар өсөж 674.4 тэрбум төгрөгт хүрсэн бол даатгалын нийт хураамж 575.7 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 1 хувиар буурч, даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ 189.1 тэрбум төгрөг болж 19 хувиар өсжээ.

Ард даатгал компани 2025 онд хураамжийн орлогын бүтцийг эргэн харж, цахим даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны процесс, харилцагчийн үйлчилгээг сайжруулах чиглэлд голлон анхаарч ажиллаа. Мөн үйл ажиллагаандаа олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй тайлагналын гурван янзын стандарт, аргачлалуудыг нэгэн зэрэг нэвтрүүлэн ажиллаж байгаа Монгол Улсын анхдагч даатгалын компани болсныг мэдэгдэхэд таатай байна. Үүнд:

- Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нягтлан бодох бүртгэлийн тайлагналын IFRS 17 стандарт;
- Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлийн (SASB) стандарт
- Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2022 стандарт

Дээрх стандартуудыг хэрэгжүүлснээр компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, мэдээллийн аюулгүй байдал, тайлагналын ил тод байдлыг олон улсын түвшинд нийцүүлж ажиллахад тодорхой ахиц дэвшил гарч, даатгагч, даатгуулагчид, зохицуулагч байгууллага, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч зэрэг сонирхогч талуудын эрх ашгийг ижил тэгш хангаж ажиллахад бодит дэмжлэг үзүүлнэ гэж үзэж байна.

Эцэст нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, даатгуулагч, харилцагч, хамтран ажиллагч түншүүд болон Ард даатгал ХК-ийн үнэт зүйлс болсон нийт ажилтнуудад Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хувиар талархсанаа илэрхийлье. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байгаадаа баяртай байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

О. Одбаяр



Нийт хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, даатгуулагч, харилцагч, түншүүд та бүхний амгаланг айлтгая.

Даатгалын салбарын ууган компаниудын нэг болох Ард даатгал компани нь 2025 онд 180 мянга гаруй даатгалын гэрээ байгуулж нийт 40.5 тэрбум төгрөгийн хураамжийг төвлөрүүлж, 12.1 мянган тохиолдолд 20.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон нь 2024 онтой харьцуулахад даатгалын хураамж 11 хувиар буурч, даатгалын нөхөн төлбөр 2 хувиар өсжээ.

Даатгалын хураамжийн орлого буурахад эрсдэлийн удирдлагын бодлогод өөрчлөлт оруулж, бүтээгдэхүүний чанар болон ашигт ажиллагааг сайжруулах хүрээнд хохирлын харьцаа өндөртэй бүтээгдэхүүний борлуулалтыг оновчтой түвшинд бууруулсан нь нөлөөлсөн. Мөн нөхөн төлбөрийн зардал өссөн хэдий ч даатгалын хураамжийн бүтэц болон хөрөнгө оруулалтыг үр ашигтай удирдсаны үр дүнд компанийн цэвэр ашиг өмнөх оноос 27 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бид 2025 онд үйл ажиллагааны процессыг улам боловсронгуй болгох, компанийн дотоод дүрэм, журмуудыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, даатгалын үйлчилгээний чанарыг сайжруулахад анхааран ажиллаа. Энэ хүрээнд үйл ажиллагаандаа Чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 олон улсын стандарт болон Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2022 олон улсын стандартыг нэвтрүүлэх замаар үйл ажиллагааны процессуудыг сайжруулан, дүрэм журмыг шинэчлэн баталж, баталгаажуулалтын сертификатыг хүлээн авлаа.

Мөн компанийн “Харилцагчийн үйлчилгээний төв”-ийг бүтэц, орон тоо, үйл ажиллагааны процесс, чиг үүрэг, харилцагчийн үйлчилгээний стандартуудыг шинэчлэн баталж, үйл ажиллагааг эхлүүллээ.

Даатгалын салбарт Монгол Улсын томоохон төсөл, хөтөлбөрүүдэд үндэсний даатгалын компаниуд нэгдэн хамтран даатгагчаар оролцох зорилгоор ажлын хэсгийг байгуулж, хамтран ажиллах гэрээг байгуулснаар “Хам даатгал”-аар улс орны хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдэд хамтран ажиллах эхлэлийг тавилаа. Энэхүү ажилд Ард даатгал компани манлайлан ажилласныг дуулгахад таатай байна.

Бидэнд итгэн эрсдэлээ даатгуулсан даатгуулагчид, компанид хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, өнгөрсөн, одоо, ирээдүйд бидэнтэй хамтран даатгалын салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж буй оролцогч талууд болон Компанийн үнэт баялаг болсон нийт ажилтнууддаа талархал илэрхийлж, 2025 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг өргөн барьж байна.



Гүйцэтгэх Захирал
Н. Эрдэнэтулга

АРД ДААТГАЛ ХК-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА



Компанийн танилцуулга

Ард даатгал ХК нь 1994 онд үүсгэн байгуулагдаж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагуудыг ханган Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2/16 тоот даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч 30 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй компани юм.

Бидний үйл ажиллагааны зарчим нь CIRCLE буюу ХҮРД гэсэн утгатай дараах бүтэцтэй.



Тоон үзүүлэлт



1994

Ард даатгал ХК үүсгэн байгуулагдаж анхны хувийн даатгалын компани болов.

2004

Их Британийн Omni Whittington Group хөрөнгө оруулав.

2010

Агаарын хөлгийн даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв.

2011

- Оюу толгой төслийн бүтээн байгуулалтад оролцож эхлэв.
- Гранд даатгал ХХК-ийг өөртөө нэгтгэв.

2012

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээг үзүүлж эхлэв.

2013

Ард санхүүгийн нэгдэл ХК хөрөнгө оруулагч болов.

2016

Малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээ үзүүлж эхлэв. ХБНГУ-ын Ханновер Ре компанитай Давхар даатгалын ТРИТИ гэрээг байгуулав

2017

MSH International Олон улсын эрүүл мэндийн даатгал, Хөдөө аж ахуйн давхар даатгал ХХК-тай хамтран Тариалангийн даатгалыг хэрэгжүүлж эхлэв.

2018

IPO гаргаж нээлттэй хувьцаат компани болов.

2019

“Ард апп”-д Даатгал цэс нэмэгдэж, онлайн даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв.

2020

Ковид 19 цар тахлын хамгаалалт бүхий шинэ даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв

2021

Даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулав.

2022

Харилцагчийн мэдээллийн бааз үүсгэж, CRM системийг хэрэгжүүлж эхлэв

2023

Жолоочийн даатгалын борлуулалтаар салбартаа тэргүүлэгч болов

2024

Салбартаа анх удаа Тогтвортой хөгжлийн тайлан гаргав. Баталгааны даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв

2025

Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001/2015, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001/2022 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэв.

Даатгалын үйл ажиллагаа

Ард даатгал ХК нь ердийн даатгалын компани бөгөөд албан журмын даатгалаас гадна сайн дурын 50 гаруй төрлийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байна. Бид жолоочийн хариуцлагын албан журмын, малын индексжүүлсэн даатгал, газар тариалангийн даатгал, баталгааны даатгалыг анхлан хэрэгжүүлэгчдийн нэг билээ.



Даатгалын багц мэдээлэл

2025 онд Даатгалын 12 хэлбэрийн 50 гаруй бүтээгдэхүүнээр нийт 28.1 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын гэрээ хийгдсэн бөгөөд Компанийн нийт хүлээж буй хариуцлагын 69 хувийг хөрөнгийн даатгал болон хариуцлагын даатгал эзэлж байна. Даатгалын нийт хураамжийн орлого 2024 оноос 11 хувь, даатгуулагчийн тоо 30 хувиар буурсан байна. Даатгалын багцын мэдээллийг хүснэгтлэн харуулбал:

Даатгалын хэлбэр	Нийт хураамж (сая төгрөг)			Даатгуулагчийн тоо (мянга)		
	2024	2025	Өөрчлөлт	2024	2025	Өөрчлөлт
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	5,320	4,822	▼ -9%	24.5	24.6	▲ 0.4%
Хөрөнгийн даатгал	6,487	6,617	▲ 2%	17.5	17.2	▼ -2%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	12,062	9,483	▼ -21%	17.1	10.5	▼ -39%
Ачааны даатгал	427	375	▼ -12%	0.2	0.9	▲ 350%
Барилга угсралтын даатгал	2,303	1,511	▼ -34%	0.02	0.016	▼ -20%
Хариуцлагын даатгал	4,372	5,308	▲ 21%	0.7	0.9	▲ 29%
Жолоочийн албан журмын даатгал	11,874	8,124	▼ -32%	194.7	121.9	▼ -37%
Бусад	2,399	4,225	▲ 76%	2.8	4.0	▲ 43%
Нийт	45,244	40,465	▼ -11%	257.5	180.0	▼ -30%

Хамтын ажиллагаа

Бид бизнесийн үйл ажиллагаандаа харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэж, нийгмийн бүхий л салбарт хүрч ажиллажээ.

Онцлох хамтын ажиллагааны төрийн бус байгууллагууд:
 BNI (Business Network International), AusCham Mongolia (Австралийн ХАҮТ), AmCham Mongolia (Америкийн ХАҮТ), BCM (Business Council of Mongolia)

Бусад:

- Монгол улс дах гадаад улсын Элчин сайдын яамд

 230

Төрийн байгууллагууд

 80%

МҮХАҮТ-ийн ТОП 100 ААН

Эрүүл мэндийн даатгал

Ард даатгал ХК нь дотооддоо **“Ард Мэнд”** эрүүл мэнд гэнэтийн ослын даатгал, олон улсын хэмжээнд **“Ard-Medicare” (Ard-Med)** эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнээр даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгуулагчдын эрүүл мэндэд тулгарсан санхүүгийн эрсдэлийг хамгаалан ажиллаж 150 мянга гаруй харилцагчдад эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын үйлчилгээг үзүүлсэн байна.



“Ard-Medicare” олон улсын эрүүл мэндийн даатгал

Дэлхийн 200 гаруй оронд 330 мянга гаруй гэрээт эмнэлгүүдээр үйлчлүүлэх өргөн сүлжээ бүхий олон улсын MSH China эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллаж, хэрэгжүүлдэг бүтээгдэхүүн юм. Тус даатгал нь даатгуулагчдад эмнэлгийн тусламж үйлчилгээг төлбөр төлөхгүйгээр Монгол улсад төдийгүй БНХАУ, Солонгос, Япон, Ази номхон далайн орнууд болон дэлхийн улс орнууд дахь сүлжээ эмнэлгүүдээс үйлчилгээ авах боломжийг олгодог.




“Ард Мэнд” эрүүл мэнд гэнэтийн ослын даатгал

Ард Мэнд даатгал нь эрүүл мэндийн даатгал болон гэнэтийн ослын даатгалыг хамтад нь хамруулсан цогц даатгалын бүтээгдэхүүн юм. Ард Мэнд даатгалын бүтээгдэхүүн нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх шатлалын эмнэлгүүдээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах боломжийг олгодог. Даатгуулагчдад даатгалын өндөр үнэлгээ бүхий хамгаалалт, уян хатан нөхцөлийг санал болгодог.

Баталгааны даатгал

Ард даатгал компани нь Даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсны дагуу даатгагчийн баталгааг үзүүлж эхэлсэн.





✓ Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2022 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, сертификатыг хүлээн авлаа.

✓ Даатгалын салбарт 2 дах удаа Тогтвортой Хөгжлийн Тайланг гаргаж, даатгалын зах зээлийн бусад оролцогч нарт энэхүү тайланг гаргахыг уриалсан үйл ажиллагааг зохион байгуулсан

✓ Олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй тайлагналын гурван янзын стандарт, аргачлалуудыг нэгэн зэрэг нэвтрүүлэн ажиллаж байгаа Монгол Улсын анхдагч даатгалын компани боллоо. Үүнд:

- Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нягтлан бодох бүртгэлийн тайлагналын IFRS 17 стандарт;
- Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлийн (SASB) стандарт
- Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2022 стандарт



✓ Даатгалын гэрээний хугацаанд даатгалын тохиолдолд гаргаж, нөхөн төлбөр аваагүй Даатгуулагч иргэдийг Ард койн-оор урамшуулах ажлыг зохион байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд нийт 73.7 мянга гаруй даатгуулагч иргэнд 650.0 сая төгрөгтэй тэнцэх 10.9 сая ширхэг Ард койныг олгосон байна

✓ Даатгуулагч, харилцагчийн дуу хоолойг сонсох, санал хүсэлт, гомдол мэдээллийг системтэйгээр хүлээн авч, дүн шинжилгээ хийх замаар үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах зорилтын хүрээнд “Харилцагчийн үйлчилгээний төв”-ийг шинэчлэн зохион байгуулсан.

✓ Ослын дуудлагыг цахимаар авч, бүртгэн баталгаажуулах үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр даатгуулагчийн цагийг хэмнэх, Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн алхам боллоо.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ



2025 оны жилийн эцсийн байдлаар Даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тоо дараах байдалтай байна.

Даатгалын компани:	18 Ердийн даатгалын компани	3 Урт хугацааны даатгалын компани	1 Давхар даатгалын компани
Даатгалын мэргэжлийн оролцогч:	63 Даатгалын зуучлагчид (компани & банк)	1,143 Даатгалын төлөөлөгчид	29 Даатгалын хохирол үнэлэгч


Ердийн даатгалын зах зээл (сая төгрөг)

Даатгагчийн тоо: 18	Зах зээл ^①	Зах зээлийн дундаж	Ард Даатгал
Даатгалын нийт хураамж	575,711	31,984	▲ 40,465
Давхар даатгалын хураамж	195,235	10,846	▼ 7,602
Даатгалын цэвэр хураамж	360,954	20,053	▲ 31,296
Орлогод тооцсон хураамж	345,954	19,220	▲ 36,506
Нийт нөхөн төлбөр	189,075	10,504	▲ 20,026
Цэвэр нөхөн төлбөр	148,692	8,261	▲ 16,994
Үйл ажиллагааны зардал	197,032	10,946	▲ 20,532
Нийт хөрөнгийн дүн	674,442	37,469	▲ 57,077
Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн	73,316	4,073	▲ 6,006
Эздийн өмчийн дүн	269,583	14,977	▲ 22,456
Хохирлын харьцаа ^①	56%	-	47%
Зардлын харьцаа ^①	60%	-	56%
Хосолсон харьцаа ^①	116%	-	103%

① СЗХ-ны "Даатгалын салбарын 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны нэгдсэн тайлангаас

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал

"Жолоочийн даатгалын тухай хууль"-ийн хэрэгжилтийг ханган Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хамрагдалтаар салбартаа тэргүүлэн ажиллаа. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээ үзүүлэгч 17 даатгалын компани байдаг бөгөөд 2025 оны жилийн эцсийн тайлангийн байдлыг графикаас харж болно. 2025 онд даатгалын зах зээлд Жолоочийн даатгалын 26 мянган тохиолдлоор 47.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бол Ард даатгал компани 7.5 мянган харилцагчид 9.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ. Энэ нь олгосон нөхөн төлбөрийн дүнгээр зах зээлийн 21%-ийг эзэлж байна. Зөвхөн Жолоочийн даатгалаар ажлын өдөр бүр 30 даатгуулагчид 40.0 орчим сая төгрөгийн нөхөн төлбөр олгож байна гэсэн тооцоо гарчээ.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



Засаглалын бүтэц, үйл ажиллагаа

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан доорх бүтэц зохион байгуулалтын дагуу 2025 онд үйл ажиллагааг явуулсан.




Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Ард даатгал ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд 2025 онд Хувьцаа эзэмшигчдийн 2 удаагийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

- Компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай
- ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, сонгох;
- Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх;
- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

Хувьцааны арилжааны мэдээ

Хувьцааны арилжааны хувьд 2025 оны 12 дугаар сард нийт 131,887 ширхэг хувьцаа, 89.3 сая төгрөгийн үнийн дүнтэй арилжаа Монголын хөрөнгийн бирж дээр хийгдсэн байна. Арилжааны хугацаанд хувьцааны дээд үнэ 748.65 төгрөг, доод үнэ 622.89 төгрөгийн хооронд хэлбэлзэж, жилийн эцсийн ханш 727.91 төгрөгөөр хаагдсан бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ 18.2 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна




Хаалтын ханш	₮727.9
Дээд болон доод ханш:	₮601.6 - ₮760
Нийт хувьцааны тоо:	25,000,000
Нийт арилжаалагдсан тоо:	3.7 сая
Нийт арилжааны дүн:	₮2.5 тэрбум

Зах зээлийн үнэлгээ:	₮18.2 тэрбум
EPS:	₮123
BVPS:	₮898.25
P/E – Үнэ/Ашиг:	5.9
P/B – Үнэ/Дансны үнэ:	0.81

Хувьцаа эзэмшигчийн бүтэц

Ард даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоо 2025 оны жилийн эцсийн байдлаар 9,312 болсон байна. Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчийн бүтцэд томоохон өөрчлөлт гараагүй байна.



Ногдол ашгийн мэдээ

Ард даатгал ХК нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 08/26 тоот тогтоолын дагуу компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас нэгж хувьцаанд 40 төгрөг буюу нийт 1,000,000,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилж, 2026 оны 4-р сарын 30-ны дотор "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь дансанд байршуулав.

	2023	2024	2025
Хувьцаа эзэмшигчдийн тоо	9,732		9,312
Хувьцааны тоо	25,000,000	Олгоогүй	25,000,000
Ногдол ашиг	750,000,000		1,000,000,000
Татварын дараах ногдол ашиг	711,138,255		950,779,780

Төлөөлөн удирдах зөвлөл


Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгосон бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 6 ердийн, 3 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

ТУЗ нь компанийн бүхий л шатанд ил тод, үнэнч шударга байдлыг эрхэмлэн, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ компанийн бодлогыг тодорхойлж, үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.




О.Одбаяр
ТУЗ-ийн дарга

Ард Санхүүгийн Нэгдэл ХК
ТУЗ-ийн гишүүн




Г. Уянга
Ердийн гишүүн

Ард Пропертиз ХХК
Гүйцэтгэх захирал



Г. Цогбадрах
Ердийн гишүүн

Ард Даатгал ХК



Б. Золбоо
Ердийн гишүүн

Ард Санхүүгийн Нэгдэл ХК
Гүйцэтгэх захирал



Н. Эрдэнэтулга
Ердийн гишүүн

Ард Даатгал ХК
Гүйцэтгэх захирал




С. Оргил
Ердийн гишүүн

Мост Финтек ХК
Захирал



Н. Хосбаяр
Хараат бус
гишүүн

Монгол Шуудан ХК
Дэд захирал



Т. Хонгорзул
Хараат бус
гишүүн

“Монгол ТВ” ХХК
Хөтөлгөч



Б. Болорчимэг
Хараат бус
гишүүн

Үүсгэн байгуулагч
Өрөг.мн

Гүйцэтгэх удирдлагын баг

Компанийн удирдлагын баг нь даатгалын салбарт олон жил ажилласан чадварлаг удирдах ажилтнуудаас бүрддэг бөгөөд олон жилийн туршлага, хамтын шийдвэр нь удирдлагын багийн харилцан ойлголцлыг бий болгож Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг амжилттай явуулах суурь болдог.



Н. Эрдэнэтулга
Гүйцэтгэх захирал



Т.Батцэнгэл
Үйл ажиллагаа, санхүү хариуцсан захирал



Г.Баярбат
Эрсдэл, хөрөнгийн удирдлагын газрын захирал



Т. Мөнх-Оргил
Даатгалын газрын захирал



Ё.Алзахгүй
Нөхөн төлбөрийн газрын захирал

Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн цалин урамшууллын тогтолцоо

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн (ТУЗ) гишүүдийн хөлсний хэмжээг компанийн дүрэмд заасан үндэслэлийн дагуу ТУЗ-ийн хурлаар тогтоодог. ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын хуралд оролцох, түүнчлэн хүлээсэн бусад үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хөлс авдаг бөгөөд уг хөлсний хэмжээ нь тухайн гишүүний оролцох ёстой хурлууд (ТУЗ, хороод, хувьцаа эзэмшигчдийн хурал)-ын ирц, оролцооны идэвхээс хамааран тогтоогдоно. Хөлсийг сар бүр олгох зохицуулалттай.

Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг ТУЗ-өөс тогтоож, баталдаг бөгөөд гүйцэтгэлд суурилсан үнэлгээний тогтолцоонд үндэслэн олгодог. Үүнд компанийн батлагдсан төлөвлөгөө, санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд, зах зээлд эзлэх байр суурь, тогтвортой хөгжлийн хэрэгжилт, залгамж халааны бодлого, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нэвтрүүлэлт, цахим шилжилтийн түвшин зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг цогцоор нь харгалзан үнэлж урамшууллыг тодорхойлно.


Компанийн засаглалын кодексийн тайлан

Зарчим	Авбал зохих оноо	2025-12-31	
		СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилтийн хувь
1-р зарчим. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт	12	8	66.7%
2-р зарчим. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7	70.0%
3-р зарчим. Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100.0%
4-р зарчим. Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83.3%
5-р зарчим. Эрсдэлийн удирдлага	8	8	100.0%
6-р зарчим. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	5	83.3%
7-р зарчим. Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100.0%
8-р зарчим. Компанийн соёл	6	5	83.3%
9-р зарчим. Хувьцаа эзэмшигчийн эрх	10	10	100.0%
Нийт оноо	72	62	86.1%

Хүний нөөц

Ард даатгал компани 2025 оны байдлаар 110 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулав. Хүний нөөцийн бодлогын хувьд ажилтны сайн сайхан байдлыг дэмжиж, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор хөрөнгө оруулалтын багц олгон, ажилтны ур чадварыг тодорхойлон, шаардлагатай ур чадварыг олгохоор сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалт хөгжлийг дэмжсэн жил болж боллоо. Хүний нөөцийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Жендер:



Боловсрол:



Компанид ажилласан жил:



Ажилтны сэтгэл ханамжийн судалгаа:

Цалин урамшуулал, гүйцэтгэлийн үнэлгээ

57%

Төвийн ажилтнууд сэтгэл ханамжтай

77%

Салбарын ажилтнууд сэтгэл ханамжтай



Ажилтны эрүүл мэнд, сайн сайхны төлөөх компанийн хүчин чармайлалт

77%

Төвийн ажилтнууд сэтгэл ханамжтай

69%

Салбарын ажилтнууд сэтгэл ханамжтай



Ажилтны сэтгэл ханамжийн судалгааны дүн

72%

Компанийн ажилчдын сэтгэл ханамж 72% байна.

Дундаж цалингийн өсөлт:



Хүний нөөцийн тоон мэдээлэл

36
Шинээр орсон ажилтан

25
Хөдөлмөрийн гэрээ цуцалсан

32.7%
Эргэцийн хувь

77%
Тогтвортой байдлын хувь



Хүний нөөцийн нийгмийн баталгаа

Компанийн зүгээс 2025 онд ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, ажиллах орчныг сайжруулах, ажил амьдралын тэнцвэрийг дэмжих чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлэв.



Ажилтнуудын санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих, хүний нөөцийн тогтвор суурьшлыг нэмэгдүүлэх зорилгоор ажилтнуудыг “Ард лизинг ХХК”-ийн “Өсдөг машин” хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамруулж, төлбөрийг Компаниас хариуцахаар холбогдох гэрээг байгуулан ажиллав.



Ажилтнуудыг тэтгэврийн нэрийн данстай болгож, үндсэн цалин болон ажилласан жилээс хамааруулсан хуримтлалыг сар бүр дансанд нь шилжүүлэх тогтолцоог хэрэгжүүлж байна.



Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах хүрээнд эрүүл мэнд болон гэнэтийн ослын даатгалд хамруулж, даатгалын хураамжийг Компани бүрэн хариуцан ажиллав. Үүний зэрэгцээ ажилтнууд ажлын байранд ирэхээс эхлэн тарах хүртэлх хугацаанд нэмэлт зардал гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор өдрийн хоол, цай, кофе, утасны төлбөрийн хөнгөлөлт, шатахууны зардлыг Компаниас хариуцаж байна.



Ажиллах орчны тав тух, байгууллагын соёлыг бэхжүүлэх зорилгоор амралт, цайны булангийн тохижилтыг сайжруулж, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулан ажиллав.



Түүнчлэн ажилтнуудын ажил, амьдралын тэнцвэрийг дэмжих хүрээнд уян хатан ажлын цагийн зохицуулалтыг хэрэгжүүлж, ажил эхлэх цагийг 08:00–09:00, тарах цагийг 17:00–18:00 болгон зохицуулснаар бага насны хүүхэдтэй ажилтнуудын гэр бүлдээ зарцуулах цаг, асран хамгаалах боломжийг нэмэгдүүлсэн.



Хүүхэд хамгаалал, гэр бүлд ээлтэй бодлогын хүрээнд компанийн хэмжээнд ажилтнуудын 0–18 насны хүүхдийн бүртгэл, мэдээллийн санг тогтмол хөтөлж байна. Мөн жил бүрийн Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилтнуудын хүүхдүүдэд бэлэг, дурсгал гардуулж, авьяас чадварыг хөгжүүлэх уралдаан, тэмцээнийг зохион байгуулан ажиллаж байна.

Сургалт, хөгжил:

Компани ажилтнуудын мэдлэг чадвар, хандлагыг сайжруулах, системтэйгээр сургаж хөгжүүлэх зорилгоор жил бүр “Сургалт хөгжлийн төлөвлөгөө”-г баталж, гадаад болон дотоод сургалтад ажилтнуудыг хамруулж ирсэн. 2025 онд нийтдээ 110 гаруй ажилтанд 450 академик цаг буюу төв оффисын нэг ажилтанд 100 академик цаг, салбарын ажилтанд 20 академик цагийн сургалтууд, нийт 40 гаруй сая төгрөгийг сургалтын зардалд зарцуулсан байна.



Компанийн залгамж халааны бодлогын хүрээнд ажилтны ур чадварыг хөгжүүлэх, мэргэшүүлэхээр МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес Академийн “Harvard Manage Mentor” сургалтад Даатгалын газрын захирал, Эрсдэл хөрөнгө удирдлагын газрын захирал болон Иргэдийн даатгалын албаны дарга нарыг хамрууллаа.



Японы ердийн даатгалын холбоо, Ердийн даатгалын институтын хамтын ажиллагааны хүрээнд жил бүр зохион байгуулагддаг “ISJ Advanced course” сургалтад компаниас нэг ажилтныг Монгол Улсаа төлөөлөн хамруулж, амжилттай төгсөж сертификатыг гардан авлаа.



Монголын Даатгалын Холбоо, Customer Business Development болон Монголын Даатгалын Институтаас хамтран зохион байгуулж буй “Даатгалын борлуулалт” эрчимжүүлсэн сургалтад Даатгалын менежерүүд оролцов.



Монголын Даатгалын Холбоо, Монголын Даатгалын Институтын хамтарсан “MII Orientation” шинэ ажилтны чиглүүлэх сургалтад 5 ажилтан хамруулсан.



Компанид “Чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO9001:2016, Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны MNS ISO/IEC 27001:2022 стандарт”-уудыг нэвтрүүлэх зорилгоор 4 сарын хугацаанд Обзерв консалтинг ХХК-иас сургалтыг авлаа.



Нэгдсэн менежментийн тогтолцооны Дотоод аудиторын сургалтанд 23 ажилтан хамрагдаж, сертификатыг гардан авав.

Олон нийтийн үйл ажиллагаа



✔ Монголын даатгалын холбооноос жил бүр зохион байгуулдаг спортын өдөрлөгт компанийн баг тамирчид амжилттай оролцлоо.

1. Эрэгтэйчүүдийн гар бөмбөгийн тэмцээнд хүрэл медаль
2. Шилдэг эрэгтэй давуулагчаар НТАМ Т.Мөнхболд
3. Ширээний теннис эрэгтэй төрөлд 4 дүгээр байранд Хөвсгөл Салбарын захирал Ц.Билгүүн

✔ Ард Санхүүгийн Нэгдэл ХК-иас удирдан зохион байгуулсан "ARD CUP" спортын олон төрөлт тэмцээнд компанийн баг хамт олон идэвх зүтгэлтэй, амжилттай оролцлоо.

- Сагсан бөмбөг (эмэгтэй) - Мөнгөн медал
- Сагсан бөмбөг (эрэгтэй) - Хүрэл медал
- Хөл бөмбөг (эрэгтэй) - Мөнгөн медал
- Хөл бөмбөг (эмэгтэй) - Хүрэл медал
- Бильярддын тэмцээнд Мөнгөн медал

Шагнал

✔ Даатгалын салбарт анх удаа зохион байгуулж буй "Mongolian Insurance Awards"-д тус компанийн ажил үйлсээрээ манлайлан ажиллаж буй ажилтнуудыг тодорхойлон нэр дэвшүүлсэн. Энэхүү арга хэмжээ 2025 оны 12 сарын 11-ний өдөр зохион байгуулагдсан бөгөөд Нөхөн төлбөрийн оны шилдэг менежер номинацид Ард Даатгал компанийн нөхөн төлбөрийн албаны Ерөнхий менежер Д.Ариунзул шалгарлаа.



✔ Санхүүгийн Зохицуулах Хорооны Санхүү, банкны тэргүүний ажилтнаар Байгууллагын даатгалын албаны Даатгалын Ерөнхий менежер О.Майбаяр, Салбарын удирдлагын албаны дарга А.Энхбаяр, Мэдээлэл технологийн ахлах инженер Н.Бямбасүрэн, Актуарч Г.Ариунжаргал

✔ Хөгжлийн яамны Эдийн засгийн тэргүүний ажилтнаар: Нягтлан бодогч Ц.Ариунцэцэг, Иргэдийн даатгалын албаны дарга Г.Сарангоо

✔ Санхүүгийн Зохицуулах Хорооны Хүндэт Жуух бичгээр: Иргэдийн даатгалын албаны Даатгалын менежер Д.Халиун, Нөхөн төлбөрийн менежер Ш.Бадамханд, Мэдээлэл технологийн инженер Г.Ганбаяр, Эрүүл мэндийн албаны дарга Б.Төгөлдөр, Хэнтий аймаг дах Салбарын Захирал Г.Ариунсүвд, Сэлэнгэ аймаг дах Салбарын захирал Ц.Оюунтуул, Дархан-Уул аймаг дах Салбарын Даатгалын менежер А.Золжаргал, Монголын Залуучуудын Холбооны "Хөдөлмөрийн алдар" шагналаар М.Батмөрөн, "Тэргүүний залуу" -аар Д.Соёлмаа нар тус тус шагнагдлаа.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА



Ард Даатгал ХК нь компанийн стратеги, үйл ажиллагааны онцлогт нийцсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх зорилгоор Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан хэрэгжүүлж байна.

Энэхүү бодлогын хүрээнд компанийн эрсдэлийг системтэйгээр тодорхойлох, үнэлэх, удирдах, хянах болон тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн аргачлалын дагуу хэрэгжүүлэхийн зэрэгцээ эрсдэлийн үнэлгээний аргачлалыг гурван үндсэн ангилалд хуваан авч үзэж, тус бүрийн хэмжилт, удирдлага, хяналт, тайлагналын аргачлалыг тодорхойлсон. Үүнд:

 <p>Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт болон түүнд хяналт тавих журамд заасан эрсдэлүүд (RBC)</p>	 <p>Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх зааварт тусгагдсан эрсдэлүүд (ORSA)</p>	 <p>Компанийн дотоод үйл ажиллагаа, бизнесийн онцлогт тулгуурлан нэмэлтээр тодорхойлсон эрсдэлүүд</p>
---	---	--

Дээрх ангиллын хүрээнд нийт **16 төрлийн эрсдэлийг** тодорхойлон, тус бүрийн хэмжилт, удирдлага, хяналт болон тайлагналын аргачлалыг боловсруулан мөрдөж байна.

Эрсдэл тус бүрийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан **“Даатгалын багц дүрэм”**-ийн хоёрдугаар хавсралтад нийцүүлэн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, хянах болон тайлагнах үйл явцыг тус бүрээр нарийвчлан тодорхойлсон.

Мөн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд оролцогч нэгж, албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагыг илүү тодорхой болгох зорилгоор **RACI матрицыг** бодлогын баримт бичигт тусгасан болно. Ингэснээр эрсдэлийн удирдлагын тогтолцоо илүү тодорхой, хариуцлагын зааг ялгаатай болж, эрсдэлийг үр дүнтэй удирдах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэж байна.

Харьцаа үзүүлэлт

Үзүүлэлт	2023	2024	2025
Хохирлын харьцаа	41%	49%	47%
Зардлын харьцаа	56%	49%	56%
Хосолсон харьцаа	97%	98%	103%


Ард даатгал компани дотоодод хийгдсэн даатгалын гэрээг Англи, Америк, Герман, Япон, Сингапур, Швейцар зэрэг олон улсын өндөр үнэлгээ бүхий давхар даатгалын томоохон компаниудад тогтмол даатгуулж ирсэн туршлагатай билээ.



Бид ХБНГУ-ын Аллианц компанитай стратегийн түншлэлийн хүрээнд урт хугацааны туршид хамтран ажиллаж байна. Мөн Ханновер Ре, Монголиан Ре, Свисс Ре зэрэг компаниуд нь манай байнгын хамтран ажилладаг давхар даатгагч бөгөөд бид өөрсдийн эрсдэлийн багцыг факультатив болон трити гэрээ байгуулан давхар даатгуулдаг.

● Давхар даатгалын хураамж: (сая төгрөг)

Давхар даатгалын гэрээ	2024 он	Хувь	2025 он	Хувь
Факультатив	3,163	44%	3,527	46%
Фронтинг	3,150	44%	3,481	46%
Трити	838	12%	595	8%
Нийт	7,150	100%	7,602	100%



● Давхар даатгалын тоон мэдээлэл (даатгалын хэлбэрээр сая төгрөг)

Давхар даатгалын гэрээ	Хураамж	Хувь	Нөхөн төлбөр	Хувь
Хөрөнгө, тээврийн хэрэгслийн даатгал	2,300	30%	1,840	100%
Ачааны даатгал	67	1%	-	-
Барилга угсралтын даатгал	758	10%	-	-
МИД	108	1%	-	-
Агаарын хөлгийн даатгал	1,311	17%	-	-
Хариуцлагын даатгал	1,911	25%	-	-
Жолоочийн хариуцлагын даатгал	48	1%	-	-
Агаарын хөлгийн хариуцлагын даатгал	957	13%	-	-
Санхүүгийн даатгал	143	2%	-	-
Нийт	7,602	100%	1,840	100%

Ард даатгал компани нь 2025 онд олгосон нөхөн төлбөрөөр салбартаа тэргүүлэгч байсан бөгөөд 2025 онд дараах ажлуудыг хэрэгжүүлж ажиллаа.

- Бид 2025 оны жилийн эцсээр 20.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг 12.1 мянган харилцагчид олгосон бөгөөд олгосон нөхөн төлбөрийн хэмжээ нь даатгалын салбарын 11 хувийг эзэлсэн байна.
- Малын индексжүүлсэн даатгалаар 2025 онд нийт 101.4 сая төгрөгийн нөхөн төлбөр олгож, зудын эрсдэлд малаа алдсан малчдад учирсан санхүүгийн хохирлыг шийдвэрлэсэн байна.
- 2025 онд 5,431 иргэн, 6,654 байгууллага, нийт 12,085 даатгуулагчид учирсан хохирлыг даатгалын гэрээний дагуу нөхөн төлсөн байна.

Даатгалын нийт нөхөн төлбөр 2024 оноос 2 хувь өсөж, нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 7 хувиар буурсан байна. Даатгалын нөхөн төлбөрийн мэдээллийг хүснэгтлэн харуулбал:

Даатгалын хэлбэр	Нийт нөхөн төлбөр (сая ₮)			Даатгуулагчийн тоо		
	2024	2025	Өөрчлөлт	2024	2025	Өөрчлөлт
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	2,440	2,129	▼ -13%	2,193	2,576	▲ 17%
Хөрөнгийн даатгал	497	2,160	▲ 335%	215	170	▼ -21%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	3,861	4,461	▲ 16%	2,470	2,103	▼ -15%
Ачааны даатгал	67	104	▲ 55%	10	12	▲ 20%
Хариуцлагын даатгал	279	166	▼ -41%	61	85	▲ 39%
Зээлийн даатгал	2,456	1,083	▼ -56%	266	171	▼ -36%
Жолоочийн албан журмын даатгал	9,366	9,848	▲ 5%	7,782	6,965	▼ -10%
Бусад	697	75	▼ -89%	1	3	▲ 200%
Нийт	19,663	20,026	▲ 2%	12,998	12,085	▼ -7%
Өдөрт шийдвэрлэсэн нөхөн төлбөрийн тоо		50			52	

Комплайнсын хөтөлбөр

Ард даатгал компани нь үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөх, бизнесийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэхийг чухалчилж ажилладаг.

2025 онд компанийн хэмжээнд **ISO 9001 Чанарын менежментийн тогтолцоо**, **ISO 27001 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо** стандартыг амжилттай нэвтрүүлж, уг стандартуудын шаардлагад нийцүүлэн дотоод дүрэм, журмуудыг шинэчлэн сайжруулж, шаардлагатай шинэ журам, зохицуулалтуудыг батлан мөрдүүлсэн.

Мөн стандартын хэрэгжилтийг хангах, компанийн үйл ажиллагааг хууль тогтоомж болон дотоод зохицуулалттай уялдуулах зорилгоор байгууллагын хэмжээнд **хууль, дүрэм журамд нийцлийн үнэлгээ** хийж хэрэгжүүллээ.

2025 онд комплайнсын үйл ажиллагааны хүрээнд дотоод дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах, компанийн засаглал болон дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- ✓ Комплайнсын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулсан. Хөтөлбөрт авлига, хээл хахууль, мэргэжлийн ёс зүйг сахих, шүгэл үлээх агуулгуудыг нэмж тусгасан
- ✓ Комплайнсын ажилтныг чадавхжуулах, мэргэшүүлэх хүрээнд холбогдох сургалтуудад байнга хамруулж сертификат авсан. Мөн нийт ажилтнуудад зориулсан танхим болон цахим хосолсон сургалтыг зохион байгуулсан
- ✓ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд Мөнгө угаах, терроризмтой тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж ТУЗ-өөр батлуулсан.
- ✓ Комплайнсийн эрсдэлийн үнэлгээний тайланг холбогдох талуудад танилцуулж шийдвэр гаргуулсан
- ✓ Хөдөлмөрийн дотоод журамдаа жендерийн тэгш эрх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс ангид байх, Комплайнсын асуудлуудыг нэмж тусган батлуулсан.
- ✓ Харилцагчийг таньж мэдэх асуулгын хуудсыг шинэчлэн даатгалын үйл ажиллагаанд нэвтрүүлж, хэрэгжилтэд сар бүр хяналт тавин дотоод тайлагнал хийж ажилласан

КОМПАНИЙН 2025 ОНЫ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

АРД ДААТГАЛ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид Ард даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-уудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бүр тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул “Ард Даатгал” ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2026 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд аудитын тайлангийн өдрөөс хойш байлансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага болон Аудитын олон улсын стандарт, Монгол улсын Аудитын тухай хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Гарын үсэг



Э. Булган
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот
2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Нексия Интернэйшнл-ийн албан ёсны, бие даасан гишүүн
Веб: www.nexia.com

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

(Мянган төгрөгөөр)	Тод	2025-12-31	2024-12-31
Даатгалын орлого	6.1	44,108,250	40,760,110
Даатгалын үйлчилгээний зардал	6.2	(26,034,778)	(25,744,203)
Даатгалын үйлчилгээний үр дүн	6.3	18,073,472	15,015,907
Давхар даатгалаас хүлээн авсан нөхөн төлбөр	6.4	1,771,010	861,360
Давхар даатгалын хураамжийн төлөлт	6.5	(7,386,781)	(6,986,039)
Давхар даатгалын цэвэр үр дүн		(5,615,771)	(6,124,679)
Даатгалын үйл ажиллагааны үр дүн	6	12,457,701	8,891,228
Хорогдуулсан хөрөнгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого		3,635,480	3,025,274
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх хөрөнгийн орлого		312,669	254,909
Цэвэр хөрөнгө оруулалтын орлого	7	3,948,149	3,280,183
Бусад орлого	8	256,402	167,966
Бусад зардал	9	(948,462)	(485,601)
Ерөнхий ба удирдлагын зардал	10	(2,637,664)	(2,567,542)
Борлуулалт, маркетингийн зардал	11	(9,464,789)	(6,372,098)
Санхүүгийн зардал		(32,092)	(2,204)
Татварын өмнөх ашиг		3,579,245	2,911,932
Орлогын албан татварын зардал	12	(482,998)	(501,530)
Тайлант үеийн цэвэр ашиг		3,096,247	2,410,402
Бусад дэлгэрэнгүй орлого		1,385,972	(24,998)
Нийт дэлгэрэнгүй орлого		4,482,219	2,385,404

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

(Мянган төгрөгөөр)	Тод	2025-12-31	2024-12-31
ХӨРӨНГӨ			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	13	4,094,011	857,984
Санхүүгийн хөрөнгө:	14	31,102,571	29,303,655
· Хорогдуулсан өртгөөр бүртгэх		27,443,021	24,827,241
· Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх		3,659,550	4,476,414
Даатгалын гэрээний хөрөнгө	15	6,284,912	9,645,560
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	15	95,468	95,469
Авлага	16	2,400,031	1,534,399
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад хөрөнгө	17	2,313,022	1,659,928
Бараа материал	18	77,366	179,612
Үндсэн хөрөнгө	19	3,013,746	1,006,845
Биет бус хөрөнгө	20	4,179,669	4,944,616
Ашиглах эрхтэй хөрөнгө	21	-	64,319
Нийт хөрөнгийн дүн		53,560,796	49,292,386
ӨР ТӨЛБӨР			
Даатгалын гэрээний өр төлбөр	15	19,929,662	25,244,082
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	15	2,821,819	1,655,706
Дансны ба бусад өр төлбөр	22	6,771,334	1,560,836
Түрээсийн өр төлбөр	23	403	70,322
Орлогын татварын өглөг	24	477,910	189,425
Хойшлогдсон татварын өр төлбөр	25	428,535	335,384
Нийт өр төлбөрийн дүн		30,429,663	29,055,755
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	26	5,000,000	5,000,000
НКТ Энгийн хувьцаа		3,280,854	3,280,854
Дахин үнэлгээний нөөц сан	27	(624,950)	(2,010,922)
Тусгай нөөц сан	28	674,790	641,253
Хуримтлагдсан ашиг		14,800,439	13,325,446
Нийт эздийн өмч		23,131,133	20,236,631
Нийт өр төлбөр ба эздийн өмч		53,560,796	49,292,386

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

(Мянган төгрөгөөр)	Эздийн өмч	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц сан	Тусгай нөөц сан	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2023 оны 12 сарын 31-ээрх	5,000,000	3,280,854	(1,985,923)	641,253	11,922,987	18,859,171
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(257,943)	(257,943)
2024 оны 1 сарын 1-ээрх залруулсан үлдэгдэл	5,000,000	3,280,854	(1,985,923)	641,253	11,655,044	18,601,228
Тайлан үеийн цэвэр ашиг	-	-	-	-	2,410,402	2,410,402
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(24,999)	-	-	(24,999)
Эздийн өмчийн өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(750,000)	(750,000)
2024 оны 12 сарын 31-ээрх	5,000,000	3,280,854	(2,010,922)	641,253	13,325,446	20,236,631
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(1,587,717)	(1,587,717)
2025 оны 1 сарын 1-ээрх залруулсан үлдэгдэл	5,000,000	3,280,854	(2,010,922)	857,984	857,984	857,984
Тайлан үеийн цэвэр ашиг	-	-	-	-	3,096,247	3,096,247
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	1,385,972	-	-	1,385,972
Эздийн өмчийн өөрчлөлт	-	-	-	33,537	(33,537)	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
2025 оны 12 сарын 31-ээрх	5,000,000	3,280,854	(624,950)	674,790	14,800,439	23,131,133

Ard

Даатгал
ХК